



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 423

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэс Монгол" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй 8 нэрийн нийт 254,187,783.97 (хоёр зуун тавин дөрвөн сая нэг зуун наян долоон мянга долоон зуун наян гурван төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоосугай.

2. "Эрдэнэс Монгол" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хуланд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэн, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003000

2022.09.29 22-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн
10/20... дугаар тогтооллын хавсралт

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	2021 оны 510 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ
1	Ниссан Навара пикап	75-46 УНР	2011	2014	28,374,704.83	28,374,704.83	-	2,500,000.00	2,500,000.00
2	Ниссан Навара пикап	75-49 УНР	2011	2014	28,374,704.83	28,374,704.83	-	2,500,000.00	2,500,000.00
3	Ниссан Навара пикап	75-62 УНР	2011	2014	28,202,603.52	28,202,603.52	-	2,500,000.00	2,500,000.00
4	Ниссан Навара пикап	75-63 УНР	2011	2014	28,202,603.52	28,202,603.52	-	2,500,000.00	2,500,000.00
5	Форд ренжер	04-85 УНӨ	2011	2014	39,356,594.26	39,356,594.26	-	-	10,000,000.00
6	Форд ренжер	04-86 УНӨ	2011	2014	39,356,594.26	39,356,594.26	-	-	12,000,000.00
7	Ландкрузер 71	79-31 УНР	2011	2014	50,166,867.32	50,166,867.32	-	-	38,000,000.00
8	УАЗ фургон	37-14 УНР	2011	2014	12,153,111.43	12,153,111.43	-	-	7,500,000.00
					254,187,783.97	254,187,783.97	-	10,000,000.00	77,500,000.00
Нийт дүн					(хоёр зуун тавин дөрвөн сая нэг зуун наян долоон мянга долоон зуун наян гурван төгрөг ерэн долоон мөнгө)		-	(арван сая)	(далан долоон сая таван зуун мянган)